



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 02

Арвайхээр

Сонгон шалгаруулалтын комисс
байгуулах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын 1.4.2, 3.1, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Арвайхээр сумын ерөнхий боловсролын Тэмүүлэл-Эрдэм сургууль, Хархорин сумын ерөнхий боловсролын Гүнзгий сургууль, Хужирт сумын ерөнхий боловсролын сургууль, Нарийнтээл сумын Баянтээг багийн ерөнхий боловсролын сургууль, Уянга сумын Жаргалант багийн ерөнхий боловсролын сургуулиудын захирал, Баруунбаян-Улаан сумын цэцэрлэг, Зүүнбаян-Улаан сумын цэцэрлэг, Богд сумын 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн сонгон шалгаруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Н.Энхцэцэг (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Салбар зөвлөлийн гишүүн)

Гишүүд: Т.Гончигдорж (аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга, Салбар зөвлөлийн гишүүн)


Э.Бадамгэрэл (Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)

Н.Чимэддорж-Ойдов (Боловсрол, соёл, урлагийн газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга)

Б.Баярмаа (Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн)

2. Сонгон шалгаруулалтыг журмын дагуу зохион байгуулж, дүнг комиссын хурлаар хэлэлцэн сонгон шалгаруулалтын тайланг 2019 оны 08 дугаар 30-ны дотор Салбар зөвлөлд хүргүүлэхийг сонгон шалгаруулалтын комисс (Н.Энхцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

013100013